2024 оны МТТАТ-ын хөрөнгөөр хээлтүүлэгч /бух/
худалдан авах ажиллагааны ажлын даалгавар

2024.04.18

Монгол Улсад нийт баталгаажсан таван үүлдрийн үхэр байдаг бөгөөд үүнд монгол үүлдэр, сарлаг, сэлэнгэ үүлдэр, дорнод монголын улаан үүлдэр, дадалын ухаа үүлдэр багтаж байна.

Хэнтий аймгийн Дадал суманд үржүүлж буй мах-сүүний хосолмол ашиг шимтэй Дадалын ухаа үхэр нь байгаль цаг уурын эрс тэс нөхцөл, бэлчээрийн маллагаанд өсөн үрждэг. Амьдын жингийн үзүүлэлтээр монгол үүлдрийн үхрээс 27.6 хувиар илүү, эх үүлдэр болох симменталь үүлдрийн үхрээс 15.4 хувиар бага байгаа нь үүлдрийн тодорхойлолттой дүйж байгаа юм.

Манай сумын үхэр сүрэг нь Дадалын “Ухаа” үүлдрийн үхэртэй ойролцоо, байгаль цаг уурын ижил төстэй нөхцөлд дасан зохицсон. Иймээс Дадалын “Ухаа” үүлдрийн үхрээр сүргийн сайжруулалтыг хийхэд тохиромжтой гэж үзэж байна.

2023 оны Малын тоо толгой албан татварын хөрөнгөөр хийгдэх ажилд иргэдээс санал дэмжигдэн 30000000 /гучин сая төгрөг/ төгрөгийн төсөвт өртгөөр өндөр ашиг шимт хээлтүүлэгч бух худалдан авахаар эрэмблэгдсэн. Өндөр ашиг шимт хээлтүүлэгч мал худалдан авах ажлыг гүйцэтгүүлэх захиалагч байгууллага Засаг даргын Тамгын газрыг төлөөлж дараах ажлын даалгаврыг санал болгож байна.

Ашиг шимийн үзүүлэлт: /Шүдлэн бух/

1. Амьдын жин 380 кг-аас дээш байх
2. Үүлдэрлэг байдал
3. Зүс - Ухаа, шар ухаа, цагаан ухаа байх
4. Гарал үүсэл, шинжилгээний бичигтэй байх
5. Цус ойртолтоос сэргийлж 1 сүргээс олон тооны шүдлэн бух нийлүүлэхгүй байх
6. 10-аас дээш тооны шүдлэн бух байх
7. Нийлүүлэх бух нь ялган тэмдэглэх хувийн дугаартай, удмын санд бүртгэгдсэн удам зүйн гэрчилгээтэй байх
8. Шаардлага хангасан шүдлэн бухны зургийг хавсаргах

Ажлын даалгавар гаргасан:

ХАА-н мэргэжилтэн Ж.Ундрах